

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Их сургуулийн дүрэм  
(2022.05.24)

Дагаж мөрдөх огноо:

2022.05.24

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Дотоод хэргийн их сургууль

Нэгжийн нэр:

Хангалт, үйлчилгээний газар

Албан тушаалын нэр:

Ахлах тогооч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-8

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баянзүрх дүүрэг, 8-р хороо Хилчний  
гудамж

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хуулиар хүлээсэн бусад үүргийг  
хэрэгжүүлэх

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Цайны газрын хоол үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, ариун цэвэр, тогооч, бэлтгэгч, сав угаагч, цайны газрын үйлчлэгч нарын хувийн ариун цэвэр, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сахиулж, соёлтой байдлыг тогтмол дээшлүүлэх, зөв зохион байгуулж хэвшүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хагас жил тутам хамрагдаж, хувийн ариун цэврийг сахих.

**Албан тушаалын зорилт:**

1. Албан хаагч, суралцагчдын хоол, үйлчилгээний хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.
2. Үйлдвэрлэлийн байранд урсгал засвар хийлгүүлж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах.
3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг бүрэн хангаж ажиллах.
4. Тогооч, бэлтгэгч, сав угаагч, үйлчлэгч нарын ажлыг хуваарилж, өдөр тутмын удирдлагаар хангаж байнгын хяналт тавьж ажиллах.
5. Хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалт хамгаалалт, зарцуулалтад хяналт тавьж, батлагдсан тооцооны дагуу материалыг хүлээн авах.
6. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, Их сургуулийн үнэт зүйлсийг дээдлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
--------	------------------------------------	-------------------------------	------------------------------

			Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Хоол үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт тогтмол хяналт тавьж, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээг баримтлан, амт чанартай халуун хоол, цай, ундаар үйлчлэх ажлыг шуурхай зохион байгуулах.</p> <p>1.2.Гал тогооны бүхий л хэсэгт ариун цэвэр, соёлч байдлыг тогтмол дээшлүүлэхийг шаардаж ариутгал, их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж хэвшүүлэх.</p> <p>1.3.Хүнсний хангалтын журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэх.</p>	Батлагдсан орц норм, жор, технологийн дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явагдсан байна.	Г  Г  Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Ажлын байранд жил бүр хийгдэх урсгал засварын талаарх саналыг удирдлагад уламжлах.</p> <p>2.2.Ажлын байранд хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, бусад эд хогшлын бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, сар бүр хяналтын тооллого явуулах.</p> <p>2.3.Хагас жил тутам эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдаж, хувийн ариун цэврийг сахих.</p>	Соёлч, цэвэр тохилог орчинг бий болгож, үйлчилгээний таатай орчин бүрдэнэ.	Г  Г  Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Ажлын байранд тавигдах стандарт шаардлага, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, үйлдвэрлэлийн технологи ажиллагааны зохион байгуулалтыг тасралтгүй сайжруулах, ажлын байрны эрүүл ахуй, гал түймрээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааг бүрэн хангаж ажиллах.	Сул цагийг багасгаж, хөдөлмөрийн бүтээмж дээшилнэ.	Г,Х
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1.Тогооч, бэлтгэгч, сав угаагч, цайны газрын үйлчлэгч нарт батлагдсан хуваарийн дагуу ажлыг хуваарилах.</p> <p>4.2.Хүнс, хуурай хэрэглэл болон мах, ногоо бэлтгэх, хоол үйлдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих,</p> <p>4.3.Ажилчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.</p> <p>4.4.Өдөр тутам бүх төрлийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг</p>	Ур чадварыг дээшлүүлж, ажлыг оновчтой зохион байгуулна.	Г,Х  Х  Г  Г,Х

	танилцуулах.		
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Агуулахаас болон нийлүүлэгч байгууллагаас ирсэн хүнсний материалын чанар байдал, стандарт үзүүлэлт, хадгалах хугацаа зэрэгт хяналт тавьж ажиллах. 5.2.Батлагдсан орц хэмжээний дагуу хоолны материал хийгдэж байгаад хяналт тавьж ажиллах.	Хүнсний аюулгүй байдал хангагдаж, үргүй зардлаас урьдчилан сэргийлнэ.	Г,Х  Г,Х
6 дугаар зорилтын хүрээнд	6.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах. 6.2.Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсээ дээдэлж, албандаа хүндэтгэлтэй хандах. 6.3.Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх чадвартай байх. 6.4.Их сургуулийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.	Албан хаагчийн сахилга, ажлын хариуцлага дээшилж, үнэт зүйлсээ дээдэлсэн байгууллагын соёл төлөвшинэ.	Г  Г  Г  Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Бүрэн дунд түүнээс дээш боловсролтой	
<b>Мэргэжил</b>	0721 Тогоочийн мэргэжлийн үнэмлэхтэй байх. Ахлагч бэлтгэх сургалтад хамрагдаж төгссөн байх.	
<b>Мэргэшил</b>	Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	
<b>Туршлага</b>		
<b>Ур чадвар</b>	<b>Дүн шинжилгээ хийх</b>	Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах. Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	<b>Асуудал шийдвэрлэх</b>	Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог. Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг.
	<b>Багаар ажиллах</b>	Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах. Дэвшил дүүргэлд өөрт хандсан үргээ гүйцэтгэх
	<b>Бусад</b>	Хүнс боловсруулах тоног төхөөрөмжтэй ажиллах ур чадвар.

### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Хангалт, үйлчилгээний газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1. Их сургуулийн албан хаагч, ажилтан, суралцагч.
2. Гэрээт байгууллагууд, ХЗДХСайдын эрхлэх

	асуудлын хүрээний улсын төсөвт, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллага, иргэд.
--	--

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b>	<b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b>
---	--

<u>Албан тушаал:</u> Захиргааны удирдлагын газрын захирал, цагдаагийн хурандаа:  Б.Эрдэнэбат 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо: ..... Дугаар: .....
---	--

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: Дотоод хэргийн их сургууль Шийдвэрийн огноо: ..... Дугаар: ..... Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа  П.Батбаатар 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр
--